



Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ойг хамтдаа тэмдэглэе!

УРИАЛГА

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ой энэ онд тохиож байна. Даян дэлхийд энх тайван тогтоож, хүний эрхийг хамгаалж, хөгжил дэвшлийг хамтран тунхагласан НҮБ-ын Дүрэм хүчин төгөлдөр болсон 10 дугаар сарын 24-ны өдрийг “НҮБ-ын өдөр” хэмээн тэмдэглэдэг уламжлалтай билээ.

НҮБ-ын гишүүн бусад улсын нэгэн адил Монгол Улс өнгөрсөн наян жилийн хөгжлийн хамтын ажиллагааны ололт амжилтаа дүгнэж цэгнэн, НҮБ-ын оролцоо, хамтын ажиллагааг илүү үр дүнтэй, тогтвортой болгон шинэчлэх үйлсэд нэгдэж байна. Гадаад харилцааны яам, Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай хамтран төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, олон нийтийг оролцуулан “НҮБ-80” жилийн ойн баярыг хамтдаа тэмдэглэх санаачилга өрнүүлж байна. Энэхүү тэмдэглэлт ойн аяны хүрээнд НҮБ-тай хамтран ажиллаж ирсэн эрхэм түншүүд болон НҮБ-ын дэмжлэг туслалцааг хүртсэн байгууллагуудад хандан олон нийтийн болон өөрсдийн мэдээллийн сувгууд, нийгмийн сүлжээгээр дараах агуулгыг дамжуулан түгээж хамтран ажиллахыг урьж байна.

- 1. “НҮБ-80” ойн баярын мэндчилгээ:** - НҮБ-тай хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, үр шимийг нь хүртсэн ажлынхаа үр дүн, эерэг нөлөөллийг олон нийтэд хуваалцаж, мэндчилгээ, сэтгэгдэл зэргээ бүтээлчээр илэрхийлэхийг уриалж байна.



2. **“Улаанбаатар - НҮБ-ын цэнхэр хот”** (#UlaanbaatarTurnsUNBlue) аяныг дэмжиж, НҮБ-ын өдрийг тохиолдуулан 2025 оны 10 дугаар сарын 24-нд төрийн байгууллагын болон олон нийтийн барилга байгууламж, хөшөө дурсгал, гүүр, цамхаг зэрэг газруудыг НҮБ-ын бэлгэ тэмдэг болсон цэнхэр өнгөөр гэрэлтүүлж, НҮБ-ын үнэт зүйлсийг дэмжиж, эв нэгдэл, хамтын хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэхийг уриалж, (#UlaanbaatarTurnsBlue) аяны дэлгэрэнгүй удирдамж, загвар, логог татаж авах холбоосыг доор хүргүүлэв.
3. **“НҮБ-80” ойн баярыг тэмдэглэх:** - “НҮБ-ын 7 хоног” аяны хүрээнд НҮБ-ын үнэт зүйлс, зарчим, үйл хэргийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн олон төрлийн арга хэмжээг өөрсдийн байгууллага дээр, эсвэл олон нийтэд хандаж зохион байгуулах, цахим мэдээллийн аян өрнүүлэх, уралдаан тэмцээн, уулзалт хэлэлцүүлэг зэргийг санаачлан зохион байгуулахыг уриалж байна.

Арга хэмжээ, үйл ажиллагаа бүр “НҮБ-80” жилийн хүрээнд та бүхний оруулсан хувь нэмэр болох тул бусдын зохион байгуулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжихийг мөн уриалж байна. Төрийн, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, иргэд та бүхэн өөрсдийн зохион байгуулсан арга хэмжээг нийгмийн сүлжээгээр түгээхдээ #UN80 #UNDAY2025 #UNMongolia #UNPartnership зэрэг hashtag ашиглаж, нийгмийн сүлжээний платформуудад хуваалцан олон нийтэд хүргэж, хамтран ажиллахыг хүсье. Дараах сошиал хаягуудыг дурьдаж болно.

<https://www.facebook.com/unmongolia>; <https://x.com/unmongolia>

<https://www.facebook.com/MFAMongoliaMN>; <https://x.com/mongoldiplomacy>

